

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/024/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
А.БАТТУШИГ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/320
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 303.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар орон нутгийн орлого төлөвлөлт болон дотоод хяналттай холбоотой 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Хатгал тосгоны Захирагч нь аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 71.7 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6700922182

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		601,029.1	827,309.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	463,034.2	648,260.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	137,994.9	179,048.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,273,988.6	2,346,477.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,273,988.6	2,346,477.9
39200	Биет хөрөнгө		2,160,964.6	2,233,856.9
39300	Биет бус хөрөнгө	13	113,024.0	112,621.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,875,017.7	3,173,786.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	5,722.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	0.0	5,722.3
41300	Өглөг	17а, 17б	0.0	5,722.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,875,017.7	3,168,064.6
51	Засгийн газрын хувь оролцоо		2,875,017.7	3,168,064.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		338,189.4	338,189.4
51200	Хуримтлагдсан үр дүн		2,343,350.6	2,636,397.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		193,477.7	193,477.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,875,017.7	3,173,786.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,828,002.2	1,737,414.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		626,968.3	839,233.0
110	Орлогын албан татвар		381,720.9	640,017.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		398,363.7	640,017.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-16,642.9	0.0
113	Хөрөнгийн албан татвар		33,491.8	38,619.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		211,755.7	160,595.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	714,094.6	207,448.2
120	Нийтлэг татварын бус орлого		710,094.6	204,298.2
121	Хөрөнгийн орлого		4,000.0	3,150.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		486,939.4	690,733.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,119,261.5	1,407,083.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,119,261.5	1,357,805.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,111,504.2	1,306,049.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		298,818.0	552,937.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		39,519.6	78,376.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		42,733.4	252,295.4
2104	Хангамж, бараа материалын зардал		164,607.1	52,500.5
2105	Нормативт зардал		0.0	4,985.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,879.9	47,244.8
2107	Томилолт, зочны зардал		883.0	10,672.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		392,674.8	97,731.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		161,388.5	209,305.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		7,757.3	51,756.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	49,277.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		708,740.8	330,331.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		24,626.2	37,284.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		684,114.6	293,046.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,246,616.6	1,635,317.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	626,968.3	839,233.0
110	Орлогын албан татвар	381,720.9	640,017.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	398,363.7	640,017.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-16,642.9	0.0
113	Хөрөнгийн албан татвар	33,491.8	38,619.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	211,755.7	160,595.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,076.3	26,067.6
1181	Газрын төлбөр	11,690.7	0.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	183,988.7	134,528.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,709.0	105,951.4
120	Нийтлэг татварын бус орлого	128,709.0	102,801.4
121	Хөрөнгийн орлого	4,000.0	3,150.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	486,939.4	690,133.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,106.4	1,216,386.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,106.4	1,216,386.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,381.0	1,164,729.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,386.8	575,670.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,467.2	84,894.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,485.7	254,364.9
2104	Хангамж, бараа материалын зардал	107,949.5	56,457.4
2105	Нормативт зардал	4,985.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,796.0	34,806.9
2107	Томилолт, зочны зардал	883.0	10,672.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,799.3	126,694.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,628.5	21,169.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,725.4	51,656.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	246,510.2	418,931.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	61,473.4	233,704.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	61,473.4	233,704.6
2200	Дотоод эх үүсвэрээр	61,473.4	233,704.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-61,473.4	-233,704.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	185,036.8	185,226.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	277,997.4	463,034.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	463,034.2	648,260.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,190,903.1	2,190,903.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,190,903.1	2,190,903.1
9	Тайлант үеийн үр дүн	684,114.6	684,114.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,017.7	2,875,017.7
i i	2024 оны i-р сарын i-нээрх үлдэгдэл	2,875,017.7	2,875,017.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,875,017.7	2,875,017.7
19	Тайлант үеийн үр дүн	293,046.9	293,046.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,168,064.6	3,168,064.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,536,131.3	1,345,490.8	190,640.5	87.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,319,925.8	1,148,274.1	171,651.7	87.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,292,912.2	1,123,257.3	169,654.9	86.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629,359.3	552,937.3	76,422.0	87.9
210101	Үндсэн цалин	505,112.1	332,266.3	172,845.8	65.8
210102	Нэмэгдэл	74,087.2	177,300.8	(103,213.6)	239.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,160.0	3,970.0	46,190.0	7.9
210104	Урамшуулал	-	39,400.2	(39,400.2)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,376.7	78,376.7	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	53,296.1	53,296.1	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,270.1	6,270.1	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,135.1	3,135.1	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,135.1	3,135.1	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,540.3	12,540.3	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	266,606.3	254,364.9	14,441.4	94.6
210301	Гэрэл, цахилгаан	68,308.6	57,130.1	11,178.5	83.6
210302	Түлш, халаалт	176,700.0	178,304.5	(1,604.5)	100.9
210303	Цэвэр, бохир ус	23,797.7	18,930.4	4,867.4	79.5
2104	Хангамж, бараа материалын зардал	50,861.3	46,920.7	3,940.6	92.3
210401	Бичиг хэрэг	7,500.0	4,766.4	2,733.6	63.6
210402	Тээвэр, шатахуун	25,940.0	26,000.0	(60.0)	100.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,421.3	4,421.3	-	100.0
210404	Ном, хэвлэл	1,500.0	500.0	1,000.0	33.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000.0	10,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500.0	1,233.0	267.0	82.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,806.9	74,996.0	31,810.9	70.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000.0	11,832.2	167.8	98.6
210602	Тавилга	10,000.0	9,915.0	85.0	99.2
210604	Урсгал засвар	84,806.9	53,248.8	31,558.1	62.8
2107	Томилолт, зочны зардал	12,500.0	9,964.0	2,536.0	79.7
210702	Дотоод албан томилолт	12,500.0	9,964.0	2,536.0	79.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,701.7	84,528.8	33,172.9	71.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,101.7	79,826.6	32,275.2	71.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300.0	1,209.6	90.4	93.0
210803	Даатгалын үйлчилгээ	500.0	376.8	123.2	75.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450.0	239.5	210.5	53.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350.0	110.0	240.0	31.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000.0	1,891.0	109.0	94.6
210807	Газрын төлбөр	1,000.0	875.4	124.6	87.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,500.0	21,169.0	7,331.0	74.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,500.0	17,541.2	1,958.8	90.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000.0	3,627.8	5,372.2	40.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,013.6	25,016.8	1,996.8	92.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,013.6	25,016.8	1,996.8	92.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,400.5	24,366.8	33.7	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,613.1	650.0	1,963.1	24.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	216,205.5	197,216.6	18,988.9	91.2
223001	Бусад хөрөнгө	216,205.5	197,216.6	18,988.9	91.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,536,131.3	1,445,173.1	90,958.2	94.1

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,834.2	-	106,834.2	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	106,834.2	-	106,834.2	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,111,319.0	1,445,173.1	(333,854.1)	130.0
320001	Орон нутгийн төсвөөс	1,111,319.0	1,338,338.9	(227,019.9)	120.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	106,834.2	(106,834.2)	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	317,978.1	-	317,978.1	-
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,086.8	-	1,086.8	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	316,891.3	-	316,891.3	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	89,871.3	(89,871.3)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,988.9	(18,988.9)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,233.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,233.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,593.2
2104	Хангамж, бараа материалын зардал	6,737.9
210401	Бичиг хэрэг	56.0
210402	Тээвэр, шатахуун	6,681.9
2107	Томилолт, зочны зардал	708.8
210702	Дотоод албан томилолт	708.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,146.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,146.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,640.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,640.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,640.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,233.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,233.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,430.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,802.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд юм.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оныг “Хүүхдийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, жилийн хөгжлийн төлөвлөгөөг 9 зорилт, 53 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж ажилласан байна.

Хатгал тосгоны захирагч нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 71.7 хувьтай биелүүлж дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам

зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалинд өөрчлөлт орсон байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд орон нутгийн ерөнхий орлого болон 1 төсөвт байгууллага, 1 орон нутгийн сан, 1 орон нутгийн өмчит ХХК нийт 6 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Захирагчийн 2023 оны А/94 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2024 онд 12 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тосгоны захирагчаар батлуулсан байна. Ажлын тайланд хяналт хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ЕБС-ийн заалны түрээсийн орлого,
- ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээний явц, гүйцэтгэлд хийх хяналтыг хэрэгжүүлээгүй
- Мөн төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Хатгал цахир ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байгаа ба тус газрын санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан гаргаагүй, нягтлан бодох бүртгэл хангалтгүй, орлогын биелэлтэд хяналт хэрэгжүүлдэггүй, татварын тайланг үнэн зөв тайлагнаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын шийдвэрлэлт:

Зөвлөмж өгөх

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хэсгийг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас дотоод аудитыг хэрэгжүүлдэг байна. Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 298.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	463.0	648.3	185.2
Бараа материал	138.0	179.0	41.1
Үндсэн хөрөнгө	2,274.0	2,346.5	72.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,875.0	3,173.8	298.8
Богино хугацаат өр төлбөр	0.0	5.7	5.7
Засгийн газрын хувь оролцоо	2,875.0	3,168.1	293.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,875.0	3,173.8	298.8

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 648.3 сая төгрөг болж, өмнөх оноос 185.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	452.6	630.3	177.6
Арилжааны банк дахь харилцах	10.4	18.0	7.6
Дүн	463.0	648.3	185.2

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 185.2 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна. Төрийн сангийн харилцах дансанд ерөнхий орлогын дансны үлдэгдэл 611.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 19.0 сая төгрөг, нийт 630.3 сая төгрөг, Арилжааны банкин дах харилцах дансанд Хатгал цахир ОНӨААТҮГ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 18.0 сая төгрөгийг тус тус нэгтгэсэн байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.4.2 Авлага

Тайлант онд авлага үүсгэж ажиллаагүй байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж төлсөн зардал гараагүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 179.0 сая төгрөг болж, өмнөх оноос 41.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	133.9	175.0	41.0
Бичиг хэргийн материал	6.2	5.6	(0.6)
Аж ахуйн материал	13.5	6.5	(7.0)
Түлш, шатах тослох материал	39.2	46.0	6.8
Барилгын засварын материал	16.0	15.5	(0.6)
Бусад хангамжийн материал	59.1	101.4	42.4
Мал амьтад	4.1	4.1	0.0
Дүн	138.0	179.0	41.1

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансанд Захирагчийн ажлын албаны хангамжийн материал 175.0 сая төгрөг, мал амьтдын дансны үлдэгдэл 4.1 сая төгрөгийг тус тус нэгтгэсэн байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар бараа материал данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.4.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,346.5 сая төгрөг болж, өмнөх оноос 72.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,161.0	2,233.9	72.9
Барилга, байгууламж, орон сууц	1,404.6	1,598.9	194.2
Хуримтлагдсан элэгдэл	(162.2)	(196.0)	(33.7)
Авто-тээврийн хэрэгсэл	730.6	672.7	(58.0)
Хуримтлагдсан элэгдэл	(115.1)	(144.1)	(28.9)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	125.7	144.7	19.1
Хуримтлагдсан элэгдэл	(79.7)	(86.4)	(6.7)
Тавилга, аж ахуйн эд хогшил	23.4	33.1	9.7
Хуримтлагдсан элэгдэл	(9.1)	(11.8)	(2.7)
Бусад үндсэн хөрөнгө	476.1	478.5	2.3
Хуримтлагдсан элэгдэл	(233.3)	(255.8)	(22.5)
Биет бус хөрөнгө	113.0	112.6	(0.4)
Програм хангамж	1.9	1.7	(0.1)
Хуримтлагдсан элэгдэл	(0.0)	(0.3)	(0.3)
Бусад биет бус хөрөнгө	111.2	111.2	-
Дүн	2,274.0	2,346.5	72.5

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансанд Захирагчийн ажлын албаны 2,233.9 сая төгрөгийн биет хөрөнгө, 112.6 сая төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдлийг тус тус нэгтгэсэн байна. Үндсэн хөрөнгийн дүн 72.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Захирагчийн ажлын алба тайлант онд 253.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авч, 125.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 5.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Татварын өглөг ЛӨҮГ/	0.0	5.7	5.7
Дүн	0.0	5.7	5.7

Хатгал цахир ОНӨААТҮГ тайлант онд 5.7 сая төгрөгийн татварын өглөг бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар өр төлбөрийн данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,168.1 сая төгрөг болж, өмнөх оноос 293.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	338.2	338.2	-
Хуримтлагдсан үр дүн	2,343.4	2,636.4	293.0
Өмнөх үеийн үр дүн	1,659.2	2,343.4	684.1
Тайлант үеийн үр дүн	684.1	293.0	(391.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193.5	193.5	-
Дүн	2,875.0	3,168.1	293.0

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансанд Захирагчийн ажлын албаны 2,525.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 19.0 сая төгрөг, Хатгал цахир ОНӨААТҮГ-ийн 12.3 сая төгрөг, Орон нутгийн ерөнхий орлогын 911.3 сая төгрөг нийт 3,168.1 сая төгрөгийг нэгтгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар засгийн газрын хувь оролцоо данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.4.9 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 3,429.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна.

Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	Тайлант он	Устгал	/сая төгрөгөөр/ Цэвэр дүн
Татварын орлого	849.2	10.0	839.2
Татварын бус орлого	379.2	171.9	204.3
Тусламж санхүүжилтийн орлого	2,200.7	1,510.0	690.7
Нийт дүн	3,429.3	1,691.9	1,737.4

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,691.9 сая төгрөгийн 16 орлогын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,549.0 сая төгрөгийн 15 орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 181.9 сая төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 39.0 сая төгрөгийн орлого, зардлын хоорондын тооцооны бичилтийг хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.2.2 дахь заалттай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын хугацаанд залруулсан.

3.4.10. Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 3,136.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Тайлант он	Устгал	/сая төгрөгөөр/ Цэвэр дүн
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,099.0	1,691.9	1,407.1
УРСГАЛ ЗАРДАЛ	3,044.8	1,686.9	1,357.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,483.0	177.0	1,306.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552.9	0.0	552.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78.4	0.0	78.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252.3	0.0	252.3
Хангамж, бараа материалын зардал	205.5	153.0	52.5

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Нормативд зардал	5.0		5.0
Эд хогшил, урсгал засварын зардал	47.2		47.2
Томиллолт, зочны зардал	10.7		10.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121.7	24.0	97.7
Бараа үйлчилгээний бусад зардал	209.3		209.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,561.8	1,510.0	51.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	37.3		37.3
НИЙТ ДҮН	3,136.3	1,691.9	1,444.4

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,691.9 сая төгрөгийн 16 зарлагын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,549.0 сая төгрөгийн 15 зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсөвт байгууллагуудын төсвийн төсөлд орлогыг 503.3 сая төгрөгөөр, зардлыг 2,085.0 сая төгрөгөөр нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан 1,421.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,216.8 сая төгрөгийг урсгал зардалд, 204.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 523.0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 106.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 568.5 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, давсан орлого дансны үлдэгдлээс 223.4 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр батлагджээ.

Тайлант онд Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор төсөвт 114.5 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 1,536.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 04 дүгээр тогтоолд зааснаар Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 600.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 904.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 150.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Татварын орлого	575.3	852.4	277.1	148.2
Үйл ажиллагааны орлого	9.0	12.0	3.0	133.1
Хөрөнгийн орлого	43.9	50.8	7.0	115.8
Хөрөнгө борлуулсны орлого	7.0	58.5	51.5	836.4
Цалин хөлс шагнал урамшуулал	320.0	517.6	197.6	161.8
Шууд бус орлого	1.0	1.0	0.0	102.5
Бууны албан татвар	2.0	2.1	0.1	105.0
Малд ногдуулах албан татвар	19.5	20.7	1.2	106.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	13.5	15.9	2.4	117.5
Улсын тэмдэгтийн хураамж	7.3	8.9	1.6	122.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.8	17.1	4.3	133.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10.0	10.0	0.0	100.0
Дуудлага худалдаа	1.0	3.2	2.2	315.0
Ойн нөөц ашигласны төлбөр	127.7	133.4	6.3	104.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	0.5	0.5	100.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5	0.5	0.0	109.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	0.0	102.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25.0	51.7	26.7	206.8
Торгуулийн орлого	18.0	39.0	21.0	216.8

Бусад орлого	7.0	12.7	5.7	181.6
НИЙТ ОРЛОГО	600.3	904.2	303.9	150.6

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Хатгал тосгоны орон нутгийн орлого 303.9 сая төгрөгөөр давж биелэхэд иргэдийн цалин хөлс өссөнөөс цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 197.6 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийг борлуулсантай холбоотойгоор хөрөнгө борлуулсны орлого 51.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрөл бүрээр нь биелүүлж ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 10.0 сая төгрөгөөр орон нутгийн орлогод төлөвлөж, бүрдүүлсэн байна. Харин Хатгал цахир ОНӨААТҮГ 2024 онд төгрөгийн хог хаягдлын төлбөрөөс 71.7 сая төгрөгийн орлого олж, зарцуулсан байна. Эндээс харахад Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ"-г баримталж, бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 31.4 сая төгрөгөөр төлөвлөж 47.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 16.0 сая төгрөгөөр буюу 151 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №-11: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/сая төгрөгөөр/
					Хувь
1	Үйлдвэр үйлчилгээний зориулалтаар ус ашигласны албан татвар	13.9	16.5	2.6	118.6
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13.5	23.8	10.3	176
3	Зам ашигласны төлбөр	4.0	7.3	3.2	180.9
	Нийт дүн	31.4	47.5	16.1	151

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 23.5 сая төгрөгөөр төлөвлөж 71.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 47.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №-12: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/мянган төгрөгөөр/
					Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	6.3	14.2	7.9	226.0
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	15.5	52.0	36.6	337.0
3	Агаарын бохирдлын төлбөр	1.8	3.3	1.4	179.0
4	Ус бохирдуулсны төлбөр	0.0	1.5	1.5	100.0
	Нийт дүн	23.6	71.0	47.4	247.0

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан 1,536.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,319.9 сая төгрөгийг урсгал зардалд, 216.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,148.3 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 197.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,148.3 сая төгрөг буюу 87.6 хувьтай байна.

Хүснэгт №6 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт/Хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,536.1	1,345.5	190.6	87.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,319.9	1,148.3	171.7	87.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,292.9	1,123.3	169.7	86.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629.4	552.9	76.4	87.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78.4	78.4	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268.8	254.4	14.4	94.6
2104	Хангамж, бараа материалын зардал	50.9	46.9	3.9	92.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106.8	75.0	31.8	70.2
2107	Томилолт, зочны зардал	12.5	10.0	2.5	79.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117.7	84.5	33.2	71.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28.5	21.2	7.3	74.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27.0	25.0	2.0	92.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	27.0	25.0	2.0	92.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	216.2	197.2	19.0	91.2

Батлагдсан төсвөөс 190.6 сая төгрөгийг зарцуулаагүй нь Захирагчийн ажлын албаны цалингийн зардлаас орон тоо дутуу ажилласантай холбоотой 76.4 сая төгрөгийн хэмнэлт хийсэн, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 24.8 сая төгрөгийг зарцуулаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авалттай 19.0 сая төгрөгийн хэмнэлтийг хийгээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нь дээд шатны төсөв захирагчаас 58.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 13.8 сая төгрөг нийт 72.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 72.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2024 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.6 Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүн.

Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий чиглэлийн хүрээнд төсвийн шууд захирагчдаас дараах судалгаануудыг авч нэгтгэсэн байна. Үүнд:

1. Ахмадын сангийн судалгаа
2. Худалдан авах ажиллагааны судалгаа
3. Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/-ийн судалгаа
4. Төсвөөс 2024 онд зарцуулсан бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын судалгаа
5. Орон тооны судалгаа

Судалгааны хүрээнд илэрсэн зөрчлийг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрлэсэн болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын төлөвлөлт, дотоод хяналт хариуцлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1/121 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1.144.3 сая төгрөгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дүнд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 22.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 32 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлж 0.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба зөрчлийг төсвийн шууд захирагчийн аудитаар шийдвэрлэсэн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 153 мэдээллийг ил тод мэдээлж 2 мэдээллийг ил тод мэдээлэх хугацаа болоогүйн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54.5.3-д заасны дагуу харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэж тайлагнасан байна.

Тайланг онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн байцад нийт 601.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж харьцуулалтын аргаар 5 тендер шалгаруулалтыг зохион байгуулж бусад ажил үйлчилгээнд шууд гэрээ байгуулж худалдан авалт

хийсэн байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд 40.1 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн орон нутгийн орлого бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	29.3	1	29.3	100
Нийт дүн	1	29.3	1	29.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 3 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Захирагчийн ажлын алба	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Хатгал цахир ОНӨААТҮГ	Түүвэрт хамрагдсан
5	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 264.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 258.9 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5.1 сая төгрөгийн 4 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар нийт 220.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 181.9 сая төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 39.0 сая төгрөгийн орлого, зардлын хоорондын тооцооны бичилтийг хийгээгүй алдааг залруулж, цэвэр дүнгээр тайлагнасан.

Аудитаар орлого төлөвлөлт болон дотоод хяналттай холбоотой 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 10.0 сая төгрөгөөр орон нутгийн орлогод төлөвлөж, бүрдүүлсэн байна. Харин Хатгал цахир ОНӨААТҮГ 2024 онд төгрөгийн хог хаягдлын төлбөрөөс 71.7 сая төгрөгийн орлого олж, зарцуулсан байна. Эндээс харахад Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ”-г баримталж, бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлтэй төлөвлөх

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Дотоод хяналтын нэгжийн 2024 оны ажлын тайланд хяналт хийхэд ЕБС-ийн заалны түрээсийн орлого, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээний явц, гүйцэтгэлд хийх хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Мөн төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Хатгал цахир ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.3. “Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтыг харьяа байгууллагуудын түвшинд бүрэн хэрэгжүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хатгал тосгоны ТТЗ	2	220.9	2	220.9			2	220.9				
Дүн	2	220.9	2	220.9			2	220.9	0	0	0	0
Харьяа байгууллагуудын алдаа												
Хатгал ЗАА	5	258.9	1	45.9	4	212.9	5	258.9				
ДҮН	5	258.9	1	45.9	4	212.9	5	258.9				
нийт дүн	7	479.8	3	266.8	4	212.9	7	479.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хатгал ТТЗ	1	0					1	0				
Дүн	1	0					1	0			0	0
Харьяа байгууллагуудын зөрчил												
Хатгал ЗАА	2	5.3	1	0.2			1	5.1				
Дүн	2	5.3	1	0.2			1	5.1				
Нийт дүн	3	5.3	1	0.2			2	5.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хатгал ТТЗ	1	-					1	
Харьяа байгууллагуудын зөрчил								
Хатгал ЗАА	3	0.0					3	0.0
Дүн	3	0.0					3	0.0
Нийт дүн	4	0.0	0	0	0	0	4	0.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: *21/25*